

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Говьсүмбэр аймгийн Нэгдсэн эмнэлэг”-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГСА-2022/26/СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Чойр хот
2022 он

Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа
Утас: 70543156
Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Наранбаяр
Утас: 70543179
Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn
Аудитор: Б.Анхтуяа
Утас: 70543179
Цахим хаяг: ankhtuyab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	Error! Bookmark not defined.
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	14
3. Аудитын тайлан.....	15
3.1 Ерөнхий зүйл.....	15
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	16
3.4 Материаллаг байдал	16
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	16
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	18
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	19
3.8 Аудитын гол асуудал	19
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	19
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	20
4. Аудитын илрүүлэлт	20
4.1 Залруулсан алдаа	20
4.2 Төлбөрийн акт	21
4.3 Албан шаардлага	21
4.4 Зөвлөмж.....	22
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	23



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: goviusumber@audit.gov.mn

2022.02.25 № 31

танай _____ -ны № _____ -т

АЙМГИЙН “НЭГДСЭН ЭМНЭЛЭГ”-
ИЙН ТӨСВИЙН ЗАХИРАГЧ
У.АРИУН-ЭРДЭНЭ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн “Нэгдсэн эмнэлэг”-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн “Нэгдсэн эмнэлэг”-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

4208020095

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АИТХ	Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
АЗДНС	Аймгийн засаг даргын нөөц сан
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
МУЕА	Монгол улсын ерөнхий аудитор
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭМЯ	Эрүүл мэндийн яам

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

			/ төгрөгөөр /
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	388,640,794.31	1,647,574,480.89
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	5,130,000.00	5,727,336.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	5,130,000.00	5,727,336.00
31210	Төгрөг	5,130,000.00	5,727,336.00
31211	Төрийн сангийн харилцах	5,130,000.00	1,490,740.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	0.00	2,905,700.00
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	0.00	1,330,896.00
33	АВЛАГА	6,008,516.36	1,053,058,717.70
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	5,976,508.36	1,803,009.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	32,008.00	1,050,063,379.70
33500	Бусад авлага	0.00	1,192,329.00
33510	Байгууллагаас авах авлага	0.00	1,192,329.00
35	БАРАА МАТЕРИАЛ	377,502,277.95	588,788,427.19
35100	Түүхий эд материал	215,001,494.71	333,418,601.75
35110	Тусгай зориулалттай материал	141,444,441.44	208,070,899.41
35130	Эм боох материал	73,557,053.27	125,347,702.34
35400	Хангамжийн материал	154,700,783.24	246,869,825.44
35410	Бичиг хэргийн материал	4,983,420.00	2,005,100.00
35420	Аж ахуйн материал	36,636,747.06	16,330,273.00
35440	Түлш, шатах тослох материал	2,174,124.00	18,547.00
35460	Хүнсний материал	15,489,678.00	8,480,441.81
35470	Бусад хангамжийн материал	95,416,814.18	220,035,463.63
35600	Мал амьтад	7,800,000.00	8,500,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,699,234,371.30	17,650,071,011.39
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,699,234,371.30	17,650,071,011.39
39100	Газар	0.00	0.00
39200	Биет хөрөнгө	5,276,574,267.03	17,227,008,407.08
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,753,723,582.60	14,525,668,550.93
39202	Хуримтлагдсан элэгдэл	-170,189,481.88	-234,044,651.86
39203	Авто-тээврийн хэрэгсэл	183,119,628.70	143,919,628.70
39204	Хуримтлагдсан элэгдэл	-93,976,929.91	-65,891,304.87
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	2,863,987,920.41	4,903,071,446.57
39206	Хуримтлагдсан элэгдэл	-1,369,779,504.52	-2,121,534,581.77
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	107,749,345.55	121,677,075.55
39208	Хуримтлагдсан элэгдэл	-42,828,104.21	-50,215,566.48
39214	Бусад үндсэн хөрөнгө	79,100,000.00	79,100,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-66,832,189.71	-74,742,189.69
39216	Дуусаагүй барилга, байгууламж	32,500,000.00	0.00

39300	Биет бус хөрөнгө	422,660,104.27	423,062,604.31
39301	Програм хангамж	1,385,000.00	1,075,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,034,895.73	-322,395.69
39303	Бусад биет бус хөрөнгө	422,310,000.00	422,310,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,087,875,165.61	19,297,645,492.28
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	32,008.00	32,008.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	32,008.00	32,008.00
41300	Өглөг	32,008.00	32,008.00
41360	Бусад өглөг	32,008.00	32,008.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	32,008.00	32,008.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,087,843,157.61	19,297,613,484.28
51	Засгийн газрын хувь оролцоо	6,087,843,157.61	19,297,613,484.28
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,058,252,156.67	3,058,252,156.67
51200	Хуримтлагдсан үр дүн	-1,075,217,433.39	12,134,552,893.28
51210	Өмнөх үеийн үр дүн	-1,280,003,297.71	-1,107,717,433.39
51220	Тайлант үеийн үр дүн	204,785,864.32	13,242,270,326.67
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,104,808,434.33	4,104,808,434.33
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,087,875,165.61	19,297,645,492.28

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,068,157,243.96	20,931,813,793.14
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	569,933,273.16	14,669,375,186.98
120	Нийтлэг татварын бус орлого	569,933,273.16	14,669,375,186.98
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	118,389,958.00	121,894,605.81
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	110,759,958.00	121,894,605.81
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,630,000.00	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	327,887,555.00	13,552,926,281.56
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	123,655,760.16	994,554,299.61
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,498,223,970.80	6,262,438,606.16
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,904,267,600.00	0.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,904,267,600.00	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	87,503,900.00	357,946,065.16

131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	4,410,788.00
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	54,146,693.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	184,994,164.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	87,503,900.00	114,394,420.16
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,506,452,470.80	5,904,492,541.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,506,452,470.80	5,904,492,541.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,863,371,379.64	7,117,121,625.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,863,371,379.64	7,117,121,625.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,852,538,191.64	6,939,821,625.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,230,168,814.20	2,936,176,994.99
210101	Үндсэн цалин	1,995,787,033.20	2,936,176,994.99
210102	Нэмэгдэл	204,820,613.00	0.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,562,000.00	0.00
210104	Урамшуулал	5,999,168.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	283,630,133.43	389,549,771.22
210201	Тэтгэврийн даатгал	194,861,730.43	271,597,195.44
210202	Тэтгэмжийн даатгал	17,753,682.00	29,492,024.95
210203	ҮОМШӨ-ний даатгал	22,192,100.00	18,728,736.55
210204	Ажилгүйдлийн даатгал	4,438,416.00	10,763,283.38
210205	Эрүүл мэндийн даатгал	44,384,205.00	58,968,530.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	345,116,523.01	535,225,864.19
210301	Гэрэл, цахилгаан	40,835,038.01	37,334,087.85
210302	Түлш, халаалт	262,970,657.00	463,726,192.34
210303	Цэвэр, бохир ус	41,310,828.00	34,165,584.00
2104	Хангамж, бараа материалын зардал	70,762,049.60	174,295,894.06
210401	Бичиг хэрэг	11,688,930.00	12,443,170.00
210402	Тээвэр, шатахуун	24,619,503.00	48,371,977.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,612,352.88	3,619,130.00

“Говьсүмбэр аймгийн Нэгдсэн эмнэлэг”-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	735,000.00	2,980,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	142,500.00	802,500.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	31,963,763.72	84,776,172.06
210408	Бараа материал акталсны зардал	0.00	21,302,945.00
2105	Нормативт зардал	498,913,759.41	1,834,992,322.54
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	412,892,096.76	1,655,551,103.54
210502	Хоол, хүнс	86,021,662.65	179,441,219.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,001,002.00	11,864,400.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,420,000.00	2,338,500.00
210604	Урсгал засвар	1,581,002.00	9,525,900.00
2107	Томилолт, зочны зардал	4,778,600.00	2,506,000.00
210702	Дотоод албан томилолт	4,778,600.00	2,506,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,824,030.00	26,980,878.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,187,448.00	15,802,594.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	396,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,350,000.00	1,594,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	310,000.00	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	205,296.00	231,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,137,686.00	9,352,484.00
210807	Газрын төлбөр	237,600.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	390,343,279.99	1,028,229,500.30
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,000.00	2,224,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,052,000.00	0.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	388,291,279.99	1,026,005,200.30
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,833,188.00	177,300,000.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	0.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	0.00	0.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,060,435.00	177,300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,060,435.00	177,300,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,772,753.00	0.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,918,753.00	0.00

“Говьсүмбэр аймгийн Нэгдсэн эмнэлэг”-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	4,854,000.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	204,785,864.32	13,814,692,167.84
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	572,421,841.17
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0.00	572,421,841.17
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	204,785,864.32	13,242,270,326.67

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,058,252,156.67	4,104,808,434.33	-1,273,107,314.40	5,889,953,276.60
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-6,895,983.31	-6,895,983.31
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,058,252,156.67	4,104,808,434.33	-1,280,003,297.71	5,883,057,293.29
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	204,785,864.32	204,785,864.32
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,058,252,156.67	4,104,808,434.33	-1,075,217,433.39	6,087,843,157.61
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,058,252,156.67	4,104,808,434.33	-1,075,217,433.39	6,087,843,157.61
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-32,500,000.00	-32,500,000.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,058,252,156.67	4,104,808,434.33	-1,107,717,433.39	6,055,343,157.61
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	13,242,270,326.67	13,242,270,326.67
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	3,058,252,156.67	4,104,808,434.33	12,134,552,893.28	19,297,613,484.28

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
		/ төгрөгөөр /	
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,616,598,787.80	5,334,269,832.27
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	118,374,817.00	121,894,605.81
120	Нийтлэг татварын бус орлого	118,374,817.00	121,894,605.81
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	118,374,817.00	121,894,605.81
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	110,744,817.00	121,894,605.81
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,630,000.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,498,223,970.80	5,212,375,226.46
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,904,267,600.00	0.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,904,267,600.00	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	87,503,900.00	357,946,065.16
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	4,410,788.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	54,146,693.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	184,994,164.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	87,503,900.00	114,394,420.16
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,506,452,470.80	4,854,429,161.30
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,506,452,470.80	4,854,429,161.30
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,551,945,835.80	5,304,835,096.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,551,945,835.80	5,304,835,096.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,541,080,639.80	5,141,265,192.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,228,838,375.00	2,928,066,528.07
210101	Үндсэн цалин	1,150,046,640.00	1,106,779,697.18
210102	Нэмэгдэл	804,517,888.08	1,573,895,028.24

“Говьсүмбэр аймгийн Нэгдсэн эмнэлэг”-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210103	Унаа хоолны хөнгөлөлт	88,873,190.12	110,991,220.35
210104	Урамшуулал	185,400,656.80	136,400,582.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	285,437,455.77	393,047,826.78
210201	Тэтгэврийн даатгал	198,437,855.77	259,316,516.33
210202	Тэтгэмжийн даатгал	21,749,900.00	49,303,538.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	17,399,900.00	24,368,895.86
210204	Ажилгүйдлийн даатгал	4,350,000.00	7,248,794.47
210205	Эрүүл мэндийн даатгал	43,499,800.00	52,810,081.21
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	345,116,523.01	0.00
210301	Гэрэл, цахилгаан	40,835,038.01	0.00
210302	Түлш, халаалт	262,970,657.00	0.00
210303	Цэвэр, бохир ус	41,310,828.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	54,293,852.88	11,095,988.00
210401	Бичиг хэрэг	9,175,700.00	0.00
210402	Тээвэр, шатахуун	23,746,500.00	0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,612,352.88	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	12,524,600.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,234,700.00	11,095,988.00
2105	Нормативт зардал	546,125,603.14	94,475,120.16
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	448,554,080.00	92,539,120.16
210502	Хоол, хүнс	88,031,923.14	1,936,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,539,600.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,805,500.00	25,400,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,581,000.00	25,400,000.00
210602	Тавилга	1,368,000.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,420,000.00	0.00
210604	Урсгал засвар	21,436,500.00	0.00
2107	Томилолт, зочны зардал	4,778,600.00	0.00
210702	Дотоод албан томилолт	4,778,600.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	47,632,730.00	24,111,557.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23,649,148.00	24,111,557.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	396,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,350,000.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	310,000.00	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	205,296.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	13,028,686.00	0.00

“Говьсүмбэр аймгийн Нэгдсэн эмнэлэг”-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210807	Газрын төлбөр	237,600.00	0.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	7,456,000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,052,000.00	1,665,068,172.26
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,000.00	1,665,068,172.26
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,052,000.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,865,196.00	163,569,904.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,060,435.00	163,569,904.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,060,435.00	163,569,904.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,804,761.00	0.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,950,761.00	0.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	4,854,000.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	64,652,952.00	29,434,736.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	59,522,952.00	28,837,400.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	59,522,952.00	28,837,400.00
2200	Дотоод эх үүсвэрээр	59,522,952.00	28,837,400.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	59,522,952.00	28,837,400.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-59,522,952.00	-28,837,400.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	5,130,000.00	597,336.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	5,130,000.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,130,000.00	5,727,336.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	/ төгрөгөөр / Тайлант оны гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	356,615,169.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	356,615,169.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	193,045,265.16
2104	Хангамж, бараа материалын зардал	11,095,988.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,095,988.00
2105	Нормативт зардал	94,475,120.16
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	92,539,120.16
210502	Хоол, хүнс	1,936,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,400,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	25,400,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,111,557.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	24,111,557.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	37,962,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	37,962,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	163,569,904.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	163,569,904.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	163,569,904.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	357,946,065.16
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	357,946,065.16
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	4,410,788.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	54,146,693.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	184,994,164.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	114,394,420.16
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	1,330,896.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,330,896.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу аймгийн “Нэгдсэн эмнэлэг”-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нэмэлт санхүүжилт, цалин хөлс, үндсэн хөрөнгөтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Анхтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Говьсүмбэр аймгийн “Нэгдсэн эмнэлэг” нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 26-ний өдрийн 01/37 дугаар албан бичгээр хуульд заасан хугацааг 1 хоногоор хоцроож ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Говьсүмбэр аймгийн “Нэгдсэн эмнэлэг”-ийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “*Ёс зүйг эрхэмлэсэн ур чадвартай эмч, мэргэжилтэн, анагаах ухааны дэвшилтэт технологи, нотолгоонд суурилсан оношлогоо эмчилгээ, сувилгааг үзүүлэх*” юм.

Зорилтууд:

- Ёс зүйг сайжруулж, үйлчилгээний стандартыг хэвшүүлэх
- Тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг эрхэмлэх
- Эрсдэлийг бууруулах
- Шинэ технологи нэвтрүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж, бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Тухайлбал: Эм эмнэлгийн хэрэгслийн тухай, Эмнэлгийн тусламжийн тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Эрүүл мэндийн тухай хуулиудад өөрчлөлт орсон. Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар" батлагдаж 11 дүгээр сараас эхлэн мөрдөгдөж эхэлсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна. Дотоод хяналтыг хэрэгжүүлээгүйн улмаас шилэн данс, татварын цахим бүртгэлийн системтэй холбоотой зөрчил давтагдсан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2021 онд аймгийн “Нэгдсэн эмнэлэг”-ийн санхүүгийн болон шилэн дансны үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говьсүмбэр аймгийн “Нэгдсэн эмнэлэг” нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалтай гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 3,863,403.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 38,634.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75.0 хувиар буюу 28,975.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Говьсүмбэр аймгийн “Нэгдсэн эмнэлэг” нь 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 13,209.8 мянган төгрөгөөр буюу 3 дахин өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	5,130.0	5,727.3	597.3

“Говьсүмбэр аймгийн Нэгдсэн эмнэлэг”-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Авлага	6,008.5	1,053,058.7	1,047,050.2
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	377,502.3	588,788.4	211,286.1
Үндсэн хөрөнгө	5,699,234.4	17,650,071.0	11,950,836.6
Нийт хөрөнгө	6,087,875.2	19,297,645.5	13,209,770.3
Өр төлбөр	32.0	32.0	0.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	6,087,843.2	19,297,613.5	13,208,163.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	6,087,875.2	19,297,645.5	13,209,770.3

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 5,727.3 мянган төгрөг болж 597.3 мянган төгрөгөөр өссөн нь ахмадын үндсэн болон нэмэлт санхүүжилтийн дансанд үлдэгдэлтэй тайлагнаснаас шалтгаалжээ.

Авлага данс 1,053,058.7 мянган төгрөг болж 1,047,050.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь ЭМДС-гаас авах санхүүжилтийн авлага нэмэгдсэнээс шалтгаалсан байна. Авлага дансны үлдэгдэлд ЭМДС-гийн санхүүжилтийн авлага 1,050,063.4 мянга, ХХОАТ-ын авлага 1,606.4 мянга, ажиллагсадтай холбогдсон авлага 196.6 мянга, байгууллагаас авах авлага 1,158.9 мянга, бусад авлага 33.3 мянга байна. Авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 588,788.4 мянган төгрөг болж 211,286.1 мянган төгрөгөөр өссөн нь ЭМЯ болон хандиваар хүлээлгэн өгсөн бараа материалаас шалтгаалжээ. Бараа материалын данс нь урсгал төсвийн худалдан авалт 1,226,334.3 мянга, иргэд, ААНБ-ын хандив 21,103.4 мянга, ЭМЯ-наас үнэ төлбөргүй өгсөн 973,450.8 мянга, данс хооронд шилжүүлэн авсан 19,676.6 мянга, нийт 2,240,565.1 мянган төгрөгөөр нэмэгдэж, зарцуулсан 1,988,299.5 мянга, даргын тушаалаар 21,302.9 мянган төгрөгийн бараа материалыг акталж, данс хооронд шилжүүлсэн 19,676.6 мянга, нийт 2,029,279.1 мянган төгрөгийн бараа материал данснаас хасагдсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 17,650.1 мянган төгрөг болж 11,950.8 мянган төгрөгөөр өссөн нь шинэ барилга ашиглалтад орж, нэмэгдсэнээс шалтгаалжээ. Тухайлбал, үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалт 28,837.4 мянга, иргэд, ААНБ-ын хандив 15,290.0 мянга, шинээр ашиглалтад орсон эмнэлгийн барилга 11,375,818.6 мянга, ЭМЯ-наас үнэ төлбөргүй өгсөн 2,107,587.0 мянга, АИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 39 дугаар тогтоолоор дахин үнэлж авсан 54,230.7 мянга, нийт 13,581,763.7 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

АИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 40 дүгээр тогтоолоор 603,873.6 мянган төгрөгийн хуучин төрөх эмнэлгийн барилгыг ЭМГ-т балансаас балансад шилжүүлж, дуусаагүй барилга, байгууламж 32,500.0 мянга, АИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 39 дүгээр тогтоолын дагуу 39 нэр төрлийн 192,443.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, нийт 828,817.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хассан байна.

Өр төлбөр данс 32.0 мянган төгрөгийг хувь хүмүүст төлөх өглөгийн үлдэгдэлтэй тайлагнасан ба тайлант хугацаанд барагдуулж ажиллаагүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 19,296,007.1 мянган төгрөг болж 13,208,163.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Говьсүмбэр аймгийн “Нэгдсэн эмнэлэг” нь санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 16,863,656.6 мянган төгрөгөөр буюу 5 дахин өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, ЭМДС-гийн санхүүжилт байна.

Нийт зардал өмнөх оноос 3,255,356.6 мянган төгрөгөөр буюу 84.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, нормативт зардлууд байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн дансанд 32,500.0 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдсэн нь дуусаагүй барилга байгууламж өөр байгууллагад шилжүүлснээс шалтгаалсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 7,056,170.8 мянга, нийт зарлагыг 7,056,170.8 мянган төгрөгөөр тус тус тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. 2021 оноос эхлэн ЭМДС-гаас гүйцэтгэлд суурилан санхүүжилт авсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр ЭМДС-гаас 4,865,491.7 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 121,894.6 мянга, нийт 4,987,386.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 4,985,895.6 мянган төгрөгийг зарцуулж, 1,490.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус газрын нэмэлт санхүүжилтийн дансанд ЭМЯ-ны тэтгэмжийн санхүүжилт 184,994.2 мянга, ЭМДС-гаас урьдчилан сэргийлэх үзлэг 11,062.5 мянга, шинжилгээний төлбөр 92,539.7 мянга, АЗДНС-гаас 54,146.7 мянга, үйл ажиллагааны орлого 10,792.8 мянга, төслийн сургалт 3,725.0 мянга, тендерийн орлого 630.0 мянга, бусад орлого 55.2 мянга нийт 357,946.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс тэтгэмж урамшууллын зардалд 184,392.0 мянга, тохижилтын зардалд 26,343.8 мянга, түргэвчилсэн оношлуур худалдан авах зардалд 92,539.1 мянга, ковид 19 цар тахлын зардалд 45,895.5 мянга, сургалтын зардалд 3,725.0 мянга, бусад зардалд 3,719.8 мянга, нийт 356,615.2 мянган төгрөгийг зарцуулж, 1,330.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Аудитаар Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108, А/111 дүгээр тушаалаар батлагдсан ерөнхий чиглэлд тусгагдсан асуудлыг онцлон авч үзсэн. Тус байгууллага нь Засгийн газрын 43 дугаар тогтоолд хамаарахгүй байгууллага учир хамрагдаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Аудитад нөлөө үзүүлэх онцлох асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Говьсүмбэр аймгийн “Нэгдсэн эмнэлэг” нь 2021 онд нийт 3,362,027.5 мянган төгрөгийн 181 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 1,113,845.9 мянган төгрөгийн 59 мэдээллийг ил тод байршуулаагүй зөрчилтэй байна. Иймд зөрчил арилгах албан шаардлага өгч ажиллалаа.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 172,911.5 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 169,330.1 мянган төгрөгийн 11 залруулга, 693.0 мянган төгрөгийн 1 зөрчилд 1 төлбөрийн акт, 2,629.9 мянган төгрөгийн 2 зөрчилд зөрчлийг арилгах 2 албан шаардлага, 4 зөрчилд алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 258.5 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн бөгөөд төлбөрийн актыг бүрэн хэрэгжүүлж, 1 албан шаардлага, 1 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 2 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	693.0	1	693.0	-	-	-
Албан шаардлага	2	2,629.9	1	2,629.9	1	0.0	75.0
Зөвлөмж	3	258.5	2	258.5	1	0.0	75.0
Нийт дүн	6	3,322.9	4	3,322.9	2	0.0	83.3

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

“Говьсүмбэр аймгийн “Нэгдсэн эмнэлэг”-ийн санхүүгийн үйл ажиллагаанд нарийвчлан авч үзэх асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,494,398.8 мянган төгрөгийн 20 алдаа зөрчил илэрснээс, 311,204.8 мянган төгрөгийн 13 алдаа, зөрчлийг аудитын явцад залруулж, 210.0 мянган төгрөгийн 1 зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 1,182,983.9 мянган төгрөгийн 4 алдаа, зөрчилд 4 албан шаардлага, 2 зөрчилд 2 зөвлөмж өгсөн байна.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай 311,204.8 мянган төгрөгийн дараах залруулгууд хийгдсэн байна.

- 4.1.1 Завсрын аудитаар НДШ, ХХОАТ-д 78,150.1 мянган төгрөгийн өр төлбөртэй тайлагнасан байсныг зөвлөмж өгч залруулсан.
- 4.1.2 Завсрын аудитаар үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих 21,045.0 мянган төгрөгийн орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллаагүй байсныг зөвлөмж өгч залруулсан.
- 4.1.3 Завсрын аудитаар тооцооны дансаар дамжуулаагүй 7,666.8 мянган төгрөгийг шууд зардалд бүртгэсэн байсныг залруулсан.
- 4.1.4 Завсрын аудитаар нярав нь тээвэр шатахуун, тусгай зориулалт, бусад хангамжийн материалын тайланг бэлтгээгүй байсныг зөвлөмж өгч залруулсан.
- 4.1.5 Завсрын аудитаар нярав нь үндсэн хөрөнгийн машин, тоног төхөөрөмж дансанд хөдөлгөөн хийгдсэн боловч тайланг бэлтгээгүй байсныг зөвлөмж өгч залруулсан.
- 4.1.6 Төсвийн хөрөнгөөр худалдаж авсан бараа материалыг үнэ төлбөргүй орлогоор бүртгэсэн, байгууллага иргэдээс хүлээн авсан хандивын бараа материалыг дутуу тусгасан нийт 100,755.2 мянган төгрөгийн алдаа байсныг аудитын явцад залруулав.
- 4.1.7 Төсвийн хөрөнгөөр худалдаж авсан үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор бүртгэсэн, хандиваар хүлээн авсан үндсэн хөрөнгийг зөрүүтэй тусгасан, дуусаагүй барилгыг хасахдаа барилгын хуримтлагдсан элэгдэл дансанд хаасан зэрэг нийт 38,350.0 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залруулав.
- 4.1.8 Мөнгөн гүйлгээний тайланд хөрөнгө худалдаж авсан зардлыг 1,350.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгасныг аудитын явцад залруулав.
- 4.1.9 Ахмадын сангийн үлдэгдэл 2,905.7 мянган төгрөгийг төсвийн харилцах дансны үлдэгдлээр тайлагнасныг аудитын явцад залруулав.

- 4.1.10 Бараа материалыг данс хооронд шилжүүлэхдээ 19,676.6 мянган төгрөгийн орлого, зарлагаар тусгасныг аудитын явцад залруулав.
- 4.1.11 Үндсэн хөрөнгийн элэгдэл 31,842.5 мянган төгрөгөөр дутуу тооцоолсныг аудитын явцад залруулав.
- 4.1.12 Мөнгөн гүйлгээний тайланд 7,856.5 мянган төгрөгийн зардал зөрүүтэй тусгасныг аудитын явцад залруулав.
- 4.1.13 ХХОАТ-ын тайлангаар үүссэн 1,606.4 мянган төгрөгийн авлага тусгаагүй, тооцоо нийлээгүй байсныг аудитын явцад залруулав.

4.2 Төлбөрийн акт

4.2.1 Нийт 3 албан хаагчдад тэтгэмж, тусламж олгохдоо 210.0 мянган төгрөгийн ХХОАТ суутгаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.1, Татварын ерөнхий газрын даргын 2019 оны А/261 дугаар тушаалын хавсралтын 2.2 дахь заалтуудыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх, батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.5, 4.2.3.8-т заасны дагуу төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

4.3 Албан шаардлага

4.3.1 Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад орлогын 8, зарлагын 29, 5 сая төгрөгөөс дээш 22 худалдан авалтын мэдээллийг тус тус мэдээлээгүй, нийт 1,113,845.9 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.4, 6.4.5, 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.3, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2.1.13, 2.2.2.5, 3 дугаар зүйлийн 3.2.9, 3.2.10 заалтуудыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т заасны дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.3.2 Худалдан авалтын гүйлгээг татварын цахим бүртгэлийн системээр шивэгдсэн эсэхийг тулгаагүйгээс 37,097.2 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.4, Сангийн сайдын 2017 оны 347-р тушаалаар батлагдсан журмын 6 дугаар зүйлийн 6.5 дахь заалтуудыг зөрчсөн, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10, 4.2.1.11-т заасны дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.3.3 Ээлжийн амралтын олговрыг цалин хөлстэй давхардуулан нийт 21,742.3 мянган төгрөг илүү тооцож олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.4, 20.2.5, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалын 1 дүгээр хавсралтын 1, 2 дахь заалтуудыг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.5, 4.2.1.11-т заасны дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.3.4 ЭМС-ын тушаалаар 2021 оны 7 дугаар сараас ажлын цагийн хэвийн горимд шилжсэн үед ажлын цагийн дунджийг 6 цагаар бодож 10,298.6 мянган төгрөгийн илүү цаг бодож олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.4, 20.2.5, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын 2 дугаар хавсралт Эрүүл мэндийн сайдын 456 дугаар тушаалын 6 дугаар хавсралтын 7.2 дахь заалтуудыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.5, 4.2.1.11-т заасны дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Илүү цагийн хөлсийг бодож олгоходоо 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын нэмэгдэл хөлс тооцож олгох хуудсанд нэгтгэж дүгнээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.4, 20.2.5, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын 2 дугаар хавсралт дахь заалтуудыг зөрчсөн, Нийцсэн бөгөөд зохистой байх, үнэлгээ ба хуваарилалт, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Илүү цагийг нэмэгдэл хөлс тооцож олгох хуудсанд бичиж, дүгнэлт хийсний дараа олгох

2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Дээд шатны төсвийн захирагч болох ЭМЯ-аас үнэ төлбөргүй хүлээлгэн өгсөн хөрөнгүүдийг хүлээж авахдаа тооцоо нийлээгүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4 дэх заалтуудыг зөрчсөн, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй байна

2.2. Өгсөн зөвлөмж:

Үнэ төлбөргүй хөрөнгө хүлээн авахдаа тооцоо нийлж, актаар баталгаажуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мян төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Говьсүмбэр аймгийн Нэгдсэн эмнэлэг	20	1,494,398.8	13	311,204.8	1	210.0	4	1,182,983.9	2	0.0